

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ОЮУНБОЛД ТАНАА

2021.02.25 № 07/547
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Туул голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Туул голын сав газрын захиргаа тайлант онд 14 зорилтын хүрээнд 39 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	842,431,658.49	608,794,581.49
33	АВЛАГА	244,939,100.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	244,939,100.00	-
34	УРЬДЧИЛГАА	548,800,000.00	548,800,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	548,800,000.00	548,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,692,558.49	59,994,581.49
351	Түүхий эд материал	1,579,000.00	-
35110	Тусгай зориулалттай материал	1,579,000.00	-
354	Хангамжийн материал	47,113,558.49	59,994,581.49
35410	Бичиг хэргийн материал	2,491,861.00	3,042,761.00
35420	Аж ахуйн материал	41,979,697.49	52,169,820.49
35430	Сэлбэг хэрэгсэл	2,535,000.00	4,056,000.00
35440	Түлш, шатах тослох материал	107,000.00	726,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	180,051,167.34	251,013,254.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	180,051,167.34	251,013,254.56
392	Биет хөрөнгө	180,009,259.16	250,593,254.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	162,771,475.19	162,771,475.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,491,813.03)	(53,630,386.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,276,144.37	102,923,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(86,151,821.23)	(35,552,434.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	260,054,706.53	190,131,287.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(204,557,447.85)	(126,422,025.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,464,961.44	24,947,825.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,626,263.26)	(14,845,377.32)
39217	Ном	269,317.00	269,317.00
393	Биет бус хөрөнгө	41,908.18	420,000.00
39301	Программ хангамж	1,105,266.00	420,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,063,357.82)	-

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,022,482,825.83	859,807,836.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,853,500.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,853,500.00	-
413	Өглөг	3,853,500.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,853,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,018,629,325.83	859,807,836.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,018,629,325.83	859,807,836.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,824.00	346,824.00
51101	Өмч: - төрийн	346,824.00	346,824.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,018,282,501.83	859,461,012.05
51210	Өмнөх үеийн үр дүн	1,018,282,501.83	1,018,282,501.83
51220	Тайлант үеийн үр дүн		(158,821,489.78)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,022,482,825.83	859,807,836.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,242,745,000.00	526,817,759.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,507,400.00	121,257,873.78
120	Нийтлэг татварын бус орлого	7,507,400.00	121,257,873.78
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,507,400.00	121,257,873.78
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,507,400.00	121,257,873.78
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,235,237,600.00	405,559,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	363,024,200.00	388,365,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	363,024,200.00	388,365,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	872,213,400.00	17,194,286.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,585,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	816,128,400.00	7,014,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,500,000.00	10,180,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	453,063,678.32	685,639,249.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,063,678.32	685,639,249.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	412,050,007.52	395,031,606.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,590,011.00	240,886,973.58
210101	Үндсэн цалин	178,100,114.00	178,479,111.84
210102	Нэмэгдэл	43,452,497.00	45,579,415.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,037,400.00	16,828,446.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,360,636.00	31,410,492.38
210201	Тэтгэврийн даатгал	20,867,185.00	21,359,136.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,454,964.00	2,512,837.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,876,929.00	2,010,273.17
210204	Ажилгүйдлийн даатгал	469,233.00	502,566.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,692,325.00	5,025,678.42

Туул голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,930,380.35	20,463,474.00
210301	Гэрэл, цахилгаан	11,375,440.00	10,896,099.00
210302	Түлш, халаалт	9,554,940.35	9,567,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,005,377.85	18,564,850.00
210401	Бичиг хэрэг	2,840,338.00	2,339,725.00
210402	Тээвэр, шатахуун	7,794,000.00	6,861,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,870,711.85	3,259,134.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,328.00	6,104,491.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,530,000.00	799,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	700,000.00	-
210604	Урсгал засвар	7,830,000.00	799,300.00
2107	Томилолт, зочны зардал	11,429,000.00	6,507,500.00
210702	Дотоод албан томилолт	11,429,000.00	6,507,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,013,428.00	22,980,230.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,554,900.00	20,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	2,160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	363,528.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,700.00	258,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	151,800.00	134,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	236,500.00	311,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,191,174.32	53,418,786.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,143,500.00	1,246,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,047,674.32	52,172,286.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,013,670.80	290,607,643.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,707,000.00	12,380,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,707,000.00	12,380,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,306,670.80	278,227,243.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,306,670.80	51,309,857.04
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/	-	226,917,386.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	789,681,321.68	(158,821,489.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	789,681,321.68	(158,821,489.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,235,237,600.00	650,498,986.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,235,237,600.00	650,498,986.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	363,024,200.00	388,365,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	363,024,200.00	388,365,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	872,213,400.00	262,133,386.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,585,000.00	4,022,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	816,128,400.00	247,930,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,500,000.00	10,180,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,219,639,600.00	647,088,986.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,219,639,600.00	647,088,986.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	933,686,829.20	356,481,342.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,590,010.00	240,886,973.58
210101	Үндсэн цалин	178,100,113.00	178,479,111.84
210102	Нэмэгдэл	43,452,497.00	45,579,415.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,037,400.00	16,828,446.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,360,637.00	31,410,492.38
210201	Тэтгэврийн даатгал	20,644,839.00	21,359,136.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,428,614.00	2,512,837.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,943,260.00	2,010,273.17
210204	Ажилгүйдлийн даатгал	485,924.00	502,566.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,858,000.00	5,025,678.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,930,380.35	20,463,474.00
210301	Гэрэл, цахилгаан	11,375,440.00	10,896,099.00
210302	Түлш, халаалт	9,554,940.35	9,567,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,572,733.85	20,552,773.00
210401	Бичиг хэрэг	3,126,046.00	2,760,635.00
210402	Тээвэр, шатахуун	7,354,000.00	10,168,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,810,711.85	2,994,134.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,281,976.00	4,629,404.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,490,640.00	6,210,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	655,000.00	999,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,839,640.00	1,150,000.00
210604	Урсгал засвар	7,996,000.00	4,061,400.00
2107	Томилолт, зочны зардал	11,429,000.00	6,507,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	568,169,928.00	29,170,230.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	565,611,400.00	26,300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	2,160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	363,528.00	115,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,700.00	258,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	151,800.00	134,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	336,500.00	201,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,143,500.00	1,279,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,143,500.00	1,279,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	285,952,770.80	290,607,643.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,707,000.00	12,380,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,707,000.00	12,380,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	273,245,770.80	278,227,243.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	273,245,770.80	51,309,857.04
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/		226,917,386.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,598,000.00	3,410,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,598,000.00	3,410,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,598,000.00	3,410,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,598,000.00	3,410,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	15,598,000.00	3,410,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	15,598,000.00	3,410,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	0.00	228,601,180.15	228,948,004.15
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	0.00	228,601,180.15	228,948,004.15
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	789,681,321.68	789,681,321.68
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	0.00	1,018,282,501.83	1,018,629,325.83
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	0.00	1,018,282,501.83	1,018,629,325.83
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(158,821,489.78)	(158,821,489.78)
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	346,824.00	0.00	859,461,012.05	859,807,836.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	388,365,600.00	337,055,742.96	51,309,857.04	86.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	388,365,600.00	337,055,742.96	51,309,857.04	86.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,985,200.00	324,675,342.96	51,309,857.04	86.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,793,800.00	240,886,973.58	38,906,826.42	86.1
210101	Үндсэн цалин	202,116,000.00	178,479,111.84	23,636,888.16	88.3
210102	Нэмэгдэл	60,068,700.00	45,579,415.21	14,489,284.79	75.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,609,100.00	16,828,446.53	780,653.47	95.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,772,100.00	31,410,492.38	6,361,607.62	83.2
210201	Тэтгэврийн даатгал	26,580,400.00	21,359,136.54	5,221,263.46	80.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,797,900.00	2,512,837.71	285,062.29	89.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,238,300.00	2,010,273.17	228,026.83	89.8
210204	Ажилгүйдлийн даатгал	559,600.00	502,566.54	57,033.46	89.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,595,900.00	5,025,678.42	570,221.58	89.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,765,700.00	20,463,474.00	3,302,226.00	86.1
210301	Гэрэл, цахилгаан	12,410,500.00	10,896,099.00	1,514,401.00	87.8
210302	Түлш, халаалт	11,355,200.00	9,567,375.00	1,787,825.00	84.3
2104	Хангамж, бараа материалын зардал	14,170,500.00	14,154,273.00	16,227.00	99.9
210401	Бичиг хэрэг	2,764,700.00	2,760,635.00	4,065.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	4,447,500.00	4,440,100.00	7,400.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,995,500.00	2,994,134.00	1,366.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,962,800.00	3,959,404.00	3,396.00	99.9
2105	Нормативт зардал	-	-	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,809,200.00	9,620,400.00	188,800.00	98.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,593,600.00	4,409,000.00	184,600.00	96.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,150,600.00	1,150,000.00	600.00	99.9
210604	Урсгал засвар	4,065,000.00	4,061,400.00	3,600.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	5,600,700.00	3,990,000.00	1,610,700.00	71.2
210702	Дотоод албан томилолт	5,600,700.00	3,990,000.00	1,610,700.00	71.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,251,500.00	2,870,230.00	381,270.00	88.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,160,000.00	2,160,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	385,000.00	115,830.00	269,170.00	30.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	258,500.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	134,400.00	63,600.00	67.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	201,500.00	48,500.00	80.6

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,821,700.00	1,279,500.00	542,200.00	70.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,821,700.00	1,279,500.00	542,200.00	70.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,380,400.00	12,380,400.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,380,400.00	12,380,400.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-	-	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,380,400.00	12,380,400.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	388,365,600.00	337,055,742.96	51,309,857.04	86.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	388,365,600.00	337,055,742.96	51,309,857.04	86.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	388,365,600.00	337,055,742.96	51,309,857.04	86.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		262,133,386.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		262,133,386.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		35,216,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,398,500.00
210402	Тээвэр, шатахуун		5,728,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		670,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл		
2107	Томилолт, зочны зардал		2,517,500.00
210702	Дотоод албан томилолт		2,517,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		26,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		26,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		226,917,386.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		226,917,386.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		262,133,386.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		262,133,386.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		4,022,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		247,930,886.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,180,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Туул голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүрэг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, шатахууны тооцоог хууль эрх зүйн актын дагуу бодож үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Шилэн баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Өлзийхишиг, аудитор Ц.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Туул голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 02/08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Туул голын сав газрын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оршино.

Туул голын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Туул голын сав газарт усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх;
- Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд цалин хөлсний нэмэгдэл, шатлалын Засгийн газрын 2020 оны 151, 184 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Туул голын сав газрын захиргаа 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин аялал, жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд Туул голын сав газрын захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 2020 оны эхний 3 улирлын гүйцэтгэлийг шалгаж, 15 мэдээлэл хоцроосон талаар дурдан, Шилэн дансны тухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Шилэн дансны цахим хуудаст тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам” батлах

тухай Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолд зааснаар шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдлыг хангаж хууль, тогтоомжид заасан хугацааг чанд мөрдөж ажиллах зөвлөгөө БОАЖЯ-ны 2020 оны 11 дүгээр сарын 03/7372 дугаар албан бичгээр тус байгууллагад ирүүлсэн байна. Дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг буруу илэрхийлэх, орхигдуулах магадлалтай тул нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон. Материаллаг байдлын буруу илэрхийллийн дүн ба шинж байдлыг харгалзан үзэх үүднээс өөдрөг үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 453,063.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,061.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 685,639.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,856.4 мянган төгрөгөөр өөрчлөн тогтоолоо.

Аудитын төлөвлөлтийн үеийн стандартаар гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нэмэгдүүлж өөрчлөхгүй гэж заасны дагуу 1 хувиар авч тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Туул голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 162,675.0 мянган төгрөгөөр буюу 15.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа, материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	244,939.1		-244,939.1
Урьдчилгаа	548,800.0	548,800.0	
Бараа материал	48,692.5	59,994.6	11,302.0
Үндсэн хөрөнгө	180,051.2	251,013.2	70,962.1
Нийт хөрөнгө	1,022,482.8	859,807.8	-162,675.0
Өр төлбөр	3,853.5		-3,853.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,018,629.3	859,807.8	-158,821.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,022,482.8	859,807.8	-162,675.0

Авлага дансны үлдэгдэлгүй болж 244,939,1 мянган төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2019 оны 5 сарын 22-ны өдрийн хуралдаанаар “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал, бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл” хэрэгжүүлэх шийдвэрээр БОАЖС-ын 2019 оны А/360 дугаар тушаалаар Агаарын орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 800,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлээс 20,000.0 мянган төгрөгийг уг төслийн хэрэгжилтэд дүгнэлт гаргуулан үлдэгдлийг тайлант оны эцэст буцаасан. Тайлант оны эцэст авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,994.6 мянган төгрөг болж 11,302.0 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 550.9, аж ахуйн материал 10,190.1, сэлбэг хэрэгсэл 1,521.0, шатахуун 726.0 мянган төгрөгөөр тус тус үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 251,013.2. мянган төгрөг болж 70,962.1 мянган төгрөгөөр өссөн нь тээврийн хэрэгсэл 56,267.6 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 3,410.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 3,410.0 мянган төгрөгийн компьютер, ханын дэлгэц авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А-1/221, БОАЖЯ-ны 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 05/673 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлөөр үнэ төлбөргүй шилжиж ирсэн 56,267.6 мянган төгрөгийн үнэ бүхий авто машинаар нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны өмнөх оны үлдэгдэл 3,853.5 мянган төгрөгийн шатахууны өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 859,807.8 мянган төгрөг болж 158,821.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны 244,939.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн авлагыг авч, тайлант онд хэрэгжилт хангалтгүй байсантай холбоотой улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг 759,269.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 361,171.2 мянган төгрөгөөр бууруулж 398,097.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд өмнөх оны батлагдсан төсвөөс багаж хэрэгсэл худалдан авах зардлыг 180,666.4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 44,961.5, албан томилолтын зардлыг 38,832.5, урсгал засварын зардлыг 19,861.6 мянган төгрөгөөр тус тус илүү төлөвлөж тусгасан байна. Мөн цалингийн зардлыг 24,564.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгасан байна.

Төсвийн төсөлд тухайн зардлуудыг нэмж төсөвлөсөн шалтгаан нь дутагдалтай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахаар, БОАЖЯ-аас байрлаж байгаа байрыг түрээслэхээр болсон, 5 аймгийн 17 сумдаар ажиллах, ажлын байр, дээврийн засвар хийх, орон нутагт бүсчлэн орон тоо нэмж ажиллуулах санал оруулан, төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 388,365.6 мянган төгрөгийн төсөв баталж улсын санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 388,365.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 337,055.7 мянган төгрөгийг зарцуулж 51,309.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 337,055.7 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь цалин, хөлсний зардлыг 38,906.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн

зардлыг 6,361.6 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 3,302.2 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1,610.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 381.3 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 542.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Цалин хөлсний хэмнэлт нь 6 орон тоо хэмнэж ажиллаж, цалингийн, нийгмийн даатгалын шимтгэлийн, бусад зардлыг ковид-19-тэй холбоотой хөл хорио тогтоосноос хэмнэсэн байна.

Мөн төсвийн хэмнэлтээс бичиг хэрэг, аж ахуйн материал, шатахуун, сэлбэг хэрэгсэл нөөцөлж, үлдэгдэл өссөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Тус байгууллагад орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй боловч Усны тухай хуулийн хэрэгжилтээр байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр ус ашиглах дүгнэлт гаргаж, үйлчилгээний хөлс 100.0 төгрөгөөр тооцож, тайлант онд 6,000.0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн санд оруулж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Усны дүгнэлтийн орлого		6,000.0	-6,000.0	

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар хуралдааны 2 дугаар тогтоол, Засаг даргын 2020 оны А/400 дугаар захирамжаар Засаг даргын нөөц сангаас 5 суманд хамгаалалтын бүс тогтоох зориулалтаар 4,180.0 мянга, Байгаль орчин уур амьсгалын сангаас Туул голын орчны цэвэрлэгээний санхүүжилт 7,014.3 мянган төгрөгийг, ус ашиглах дүгнэлтийн үйлчилгээний хөлс 6,000.0 нийт 17,194.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсөнд 26,300.0 мянга, шуудан холбооны зардалд 5,728.5 мянга, албан томилолтын зардалд 2,517.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авах зардалд 670.0 мянган нийт 35,216. мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 226,917.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 130 мэдээллийг хугацаанд нь 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлагыг биелүүлэн ажилласан.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 2,530.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа 1 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэв.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 15 мэдээлэл, мөн 2 мэдээллийг байршуулсан боловч Мөнгөн хөрөнгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээний тушаал, шийдвэрийг оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээлэх заалт, Эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Урьдчилж төлсөн зардлаар тайлагнагдсан “Ховд тул” ХХК гүйцэтгэгчтэй “Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал, бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх төсөл”-ийн санхүүжилтийн 548,800.0 мянган төгрөгийг гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Зам тээвэр, хөгжлийн сайдын баталсан нормыг мөрдөж, шатахуун зарцуулалтын 2,530.0 мянган төгрөгт тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.
- 1.2. Эрсдэл: Шатахуун илүү зарцуулж, хувийн хэрэгцээнд ашиглах.
- 1.3. Өгсөн зөвлөмж:
Шатахууны тооцоог нягтлан бодох бүртгэлийн аргачлалын дагуу бодож, бүртгэлээр тавих, хяналтыг сайжруулан ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021 он	Аудитын нэр: Туул голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/40/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Туул голын сав газрын захиргаа	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шатахууны тооцоо бүрэн боддоггүй, нормативыг мөрдөж ажилладаггүй байна.	2,530.0	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Оюунболд О.Нэргүй
2	Шилэн дансны цахим мэдээлэл зарцуулсан мөнгөн хөрөнгийн шийдвэрийг хавсралтаар оруулаагүй байна.		Албан шаардлага	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч	Б.Оюунболд О.Нэргүй
ДҮН		2,530.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 150/A0170078

Улаанбаатар хот

САГ - 2021/40/СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Туул голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 145 мэдээллээс хугацаа хоцроосон 15 мэдээлэл, мөн 2 мэдээллийг байршуулсан боловч Мөнгөн хөрөнгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 гүйлгээний тушаал, шийдвэрийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т байгууллага дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг, гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Туул голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунболд, нягтлан бодогч О.Нэргүй нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ШИЛЭН БАЛАНС АУДИТ ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ
Б.ӨЛЗИЙХИШИГ

